

2021 он 05 сар 21 өдөр

Дугаар 21/09

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Гүйцэтгэх захирал томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 5 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ганхуяг овогтой Бат-Эрдэнийг 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн Е-Моние ХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд томилсугай.
2. Гүйцэтгэх захирал томилогдсонтой холбоотой арилжааны банкуудад данс нээх, уг дансыг захиран зарцуулах эрхийг Г.Бат-Эрдэнэд олгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг хүний нөөцийн ажилтан Б.Уянгад даалгасугай.

ДАРГА



Г. УЯНГА

2021 он 05 сар 21 өдөр

Дугаар 21/02

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Гүйцэтгэх захирал чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 5 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Чулуунбаатар овогтой Хандааг 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрөөр тасалбар болгон Е-Моние ХК-ийн гүйцэтгэх захирлаас чөлөөлсүгэй.
2. Ч.Хандаатай холбогдох тооцоог хийж, цалин урамшууллыг олгохыг нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

ДАРГА



Г. УЯНГА

2021 он 05 сар 21 өдөр

Дугаар 21/67

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлж, түр гишүүн томилох тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйл, 77.5 дахь заалт, төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 21-ний хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ТУЗ-ийн доорх гишүүдийг өөрийн хүсэлтээр ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлсүгэй.
Үүнд:
 - 1.1. Ганбат овогтой Оргил
 - 1.2. Чулуунбаатар овогтой Хандаа
 - 1.3. Долинггор овогтой Ганзориг
2. Е-Моние ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн түр гишүүнээр доорх гишүүдийг түр томилсугай.
 - 2.1. Ганхуяг овогтой Бат-Эрдэнэ;
 - 2.2. Нацагдорж овогтой Цогт;
 - 2.3. Ванчиг овогтой Ганзориг.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилийг хангаж ажиллахыг хуульч (Ө. Ашхүү), Е-Моние ХК-ийн Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Г.УЯНГА

